



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13




Экспорт өмнөх сараас 18.9 хувиар өслөө

Монгол Улс 2022 оны эхний улиралд нийт 126 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.6 тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.9 тэрбум америк доллар, импорт 1.7 тэрбум америк доллар байна.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 108.7 (3.1%) сая америк доллароор, импорт 167.0 (11.0%) сая америк доллароор тус тус өсөж, харин экспорт 58.3 (2.9%) сая америк доллароор буурчээ. Экспорт өмнөх сараас 121.3 (18.9%) сая америк доллароор, импорт 171.8 (35.7%) сая америк доллароор тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ, сараар, сая америк доллароор



Гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний улиралд 476.6 сая америк долларын ашигтай байсан бол 2022 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 225.3 сая америк доллароор буурч, 251.4 сая америк долларын ашигтай гарчээ. Харин 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 50.5 сая америк доллароор буурчээ.

Хятад Улстай 2022 оны эхний улиралд 2.1 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 56.6 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ЭКСПОРТ, гол түнш улсаар, жил бүрийн

1 дүгээр улирлын байдлаар

Улс орон	2020 I-III		2021* I-III		2022* I-III	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	1 035.8	100.0	2 000.3	100.0	1 942.0	100.0
Хятад	904.7	87.3	1 850.3	92.5	1 530.0	78.8
Швейцар	32.3	3.1	1.1	0.1	288.4	14.9
Орос	11.0	1.1	27.8	1.4	42.8	2.2
Сингапур	5.8	0.6	49.9	2.5	38.0	2.0
Итали	5.4	0.5	2.5	0.1	13.2	0.7
Бусад	76.6	7.4	68.8	3.4	29.6	1.5

Хятад Улсад экспортолсон бараа бүтээгдэхүүний 46.5 хувийг зэсийн баяжмал, 41.0 хувийг чулуун нүүрс эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.8 хувийг алт эзэлж байна.

Экспорт 2022 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 58.3 сая америк доллароор буурахад нүүрсний экспорт 16.7 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.


ХҮСНЭГТ 2. УУЛ УУРХАЙН ГАРАЛТАЙ ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		2022* I-III	Үнийн дүн		2022* I-III
		2021* I-III	2022* I-III	2021* I-III	2021* I-III	2022* I-III	2021* I-III
		сая ам.доллар					
Зэсийн баяжмал	мян.т	316.3	334.8	105.8	621.1	710.9	114.5
Нүүрс	мян.т	6 773.8	2 523.2	37.2	692.3	675.6	97.6
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	т	0.4	4.8	10.9 ¹	25.7	288.0	11.2 ¹
Төмрийн хүдэр, баяжмал	мян.т	1 912.6	616.2	32.2	238.5	57.5	24.1
Боловсруулаагүй газрын тос	мян.барр	1 422.1	-	-	78.4	-	-

¹ Дахин их


Нүүрсний хилийн дундаж үнэ сүүлийн 2 сар дараалан өссөн бол боловсруулаагүй газрын тос экспортод гаргаагүй байна.

ЗУРАГ 2. ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сараар ам.доллаароор



Экспорт 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 121.3 сая америк доллароор өсөхөд чулуун нүүрсний экспорт 166.4 сая америк доллароор өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

ЗУРАГ 3. ЧУЛУУН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН, сараар



2022 оны эхний улирлын байдлаар импортын дүнг авч үзвэл, Орос 32.0%, Хятад 31.2%, Япон 8.2%, БНСУ 4.8%, Америк 3.5%, Герман 2.5 хувийг тус тус эзэлж, нийт импортын 82.1 хувийг бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 3. ИМПОРТ, гол түнш улсаар, жил бүрийн эхний улирлын байдлаар

Улс орон	2020 I-III		2021* I-III		2022* I-III	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	1 161.6	100.0	1 523.7	100.0	1 690.7	100.0
Орос	389.6	33.5	409.6	26.9	540.5	32.0
Хятад	336.5	29.0	595.9	39.1	526.7	31.2
Япон	88.0	7.6	117.0	7.7	139.4	8.2
БНСУ	46.0	4.0	59.6	3.9	80.3	4.8
Америк	63.3	5.5	65.2	4.3	58.9	3.5
Герман	44.7	3.9	48.5	3.2	42.8	2.5
Бусад	193.4	16.6	227.9	15.0	302.0	17.9

Орос Улсаас импортоор оруулсан барааны 57.1 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 71.2 хувийг суудлын автомашин, Хятад Улсаас импортолсон барааны 6.6 хувийг цахилгаан эрчим хүч, 5.8 хувийг ачааны тэрэг, 87.6 хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлж байна.

Импорт өмнөх оны мөн үеэс 167.0 сая америк доллароор өсөхөд автобензин 90.4 сая америк доллар, суудлын автомашин 28.0 сая америк доллар, дизелийн түлшний импорт 15.3 сая америк доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 4. ИМПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		2022* I-III	Үнийн дүн		2022* I-III
		2021* I-III	2022* I-III	2021* I-III	2021* I-III	2022* I-III	2021* I-III
		сая ам.доллар					
Дизелийн түлш	мян.т	273.7	198.3	72.5	135.8	151.1	111.3
Автобензин	мян.т	112.7	179.7	159.5	56.0	146.5	2.6 ¹
Суудлын автомашин	мян.ш	15.1	14.8	97.8	91.7	119.7	130.5
Ачааны автомашин	мян.ш	6.8	5.2	76.2	127.2	46.6	36.6
Цахилгаан эрчим хүч	сая кВт.ц	453.9	529.9	116.7	41.2	45.8	111.1

Эрдэс бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл, гоёлын зүйлс болон нэхмэл бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 97.3 хувийг эзэлж байгаа бол импортын 61.8 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүн эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. ЭКСПОРТ, ИМПОРТ, зарим барааны бүлгээр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2020 I-III	2021* I-III	2022* I-III	2022* I-III
	сая ам.доллар			2021* I-III
				хувь
Экспорт	1 035.8	2 000.3	1 942.0	97.1
Эрдэс бүтээгдэхүүн	886.0	1 776.2	1 531.3	86.2
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	5.2	32.7	1.1	3.4
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	3.3	54.0	2.0	3.7
Нэхмэл бүтээгдэхүүн	25.6	35.7	69.2	193.6
Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс	80.4	27.4	288.7	10.5 ¹
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	80.4	25.7	288.0	11.2 ¹
Импорт	1 161.6	1 523.7	1 690.7	111.0
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	89.7	123.7	167.3	135.2
Эрдэс бүтээгдэхүүн	284.0	276.8	386.5	139.6
Автобензин	70.6	56.0	146.5	2.6 ¹
Дизелийн түлш	125.3	135.8	151.1	111.3
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	80.3	99.8	159.2	159.5
Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги	190.6	346.7	222.0	64.0
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	79.0	97.4	124.7	128.1
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	41.8	57.8	68.8	119.1
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл	240.7	263.0	269.1	102.3

¹ - Дахин их

Ойлголт, тодорхойлолт

Гадаад худалдааны барааны нийт эргэлт: Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

Гадаад худалдааны тэнцэл: Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.

Реимпорт: Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно.

Реэкспорт: Өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.

Эх орны үйлдвэрлэлийн бараа: Тухайн улс оронд импортоор оруулж, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.



Эх үүсвэр:

Гаалийн ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 5 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Н.Адъяадорж
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212